



ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВ
2025 ОНЫ "ЭКО ХООЛ" ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүүхдийн Урлан Бүтээх төвөөс нийт албан хаагчдын эрүүл хооллолтыг дэмжсэн "Эко хоол" өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. Тус арга хэмжээ нь тухайн жилийн онцлогоос хамааран өөр өөр сэдвийн хүрээнд хэрэгждэг. Эрүүл хооллолт нь хоол хүнсээ зөв танин мэдэх, зөв хооллох дадалд суралцах, эзэмшихээс эхлэх бөгөөд таны юу идэж байгаа төдийгүй, ямар хэмжээгээр идэж байгаагаас ихээхэн шалтгаалдаг. Хоол хүнснийхээ зүйлийг зөв сонгож, зохистойгоор хэрэглэснээр зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин зэрэг өвчнөөр өвдөх эрсдэлийг багасгах төдийгүй, сэтгэл санааны хямралд орохоос урьдчилан сэргийлнэ. Үүний зэрэгцээ зөв хооллож сурснаар Таны эрүүл мэнд, ой ухаан сайжирч, эрч хүч нэмэгдэж, сэтгэл санаа тань тогтворжиход оршино.

Хоёр. Зорилго

Байгууллагын албан хаагчдын дунд эерэг харилцаа тогтоох, эрүүл зөв хооллолтын соёлыг нэвтрүүлэх, албан хаагчдын бүтээлч сэтгэлгээ, багийн ажиллагаа зэргийг нэмэгдүүлэхэд оршино.

Гурав. Сэдэв

Хямд зардлаар бүтсэн, өдөр тутмын энгийн хэрэглээний хүнс, хүнсний бүтээгдэхүүнээр 3-5 төрлийн хоол, зууш, салат бэлтгэх. (Архи, согтууруулах ундааны төрлийн шингэн хүнс, хүнсний бүтээгдэхүүн ашиглахыг хориглоно) Мөн НИЙТ ХООЛОНД АШИГЛАГДАХ ЗАРДАЛ 100.000₮-өөс давахгүй байх.

Дөрөв. Шагналт

1. Тэргүүн байр – цалингийн 10%-ийн урамшуулал
2. Дэд байр – цалингийн 5%-ийн урамшуулал
3. Гутгаар байр – цалингийн 5%-ийн урамшуулал

Тав. Хугацаа

2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 12:00 минут.

Зургаа. Хаана

Хүүхдийн Урлан Бүтээх төвийн байр, Ёслолын танхим.

Долоо. Хамрах хүрээ

Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт албан хаагчид 6 багт хуваагдан өрсөлдөх.

БОЛОВСРУУЛСАН,
НИЙГМИЙН АЖИЛТАН

 Б.АРИУНБАТ

ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВ
"ЭКО ХООЛНЫ ӨДӨРЛӨГ-2025"-ИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөнийг үндэслэн Байгууллагын албан хаагчдын дунд эерэг харилцаа тогтоох, эрүүл зөв хооллолтын соёлыг нэвтрүүлэх, албан хаагчдын бүтээлч сэтгэлгээ, багийн ажиллагаа зэргийг нэмэгдүүлэхэд оршино. Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт албан хаагчдын дунд "Эко хоолны өдөрлөг-2025"-ийг 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулав.

Тус өдөрлөгийн хүрээнд нийт албан хаагчдыг 6 багт хувааж баг тус бүр өөр өөрсдийн сонгосон өнгийн дагуу түүний онцлог шинж чанарт нийцүүлсэн эрүүл хоол, хүнсийг бэлтгэн өрсөлдөв.

Шалгаруулалтыг Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирал Д.Уранбилэг явуулж тэргүүн байр "Happy red" баг, дэд байр "Мөрөөдөл" баг, гутгаар байр "Октаграм" баг тус тус шалгарав.

Үр дүн:

Баг бүр өдөр тутмын хэрэглээнд нийцсэн хүний биед тустай хүнс, хүнсний бүтээгдэхүүнээр хэрхэн хоол бэлтгэх аргад суралцан, эрүүл хооллолтын талаар мэдлэг ойлголттой болсон.



(Үйл ажиллагааны зураг)

ХЯНАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ОТГОНТУЯА

ТАЙЛАГНАСАН:

НИЙГМИЙН АЖИЛТАН

Б.АРИУНБАТ



**ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВ
НИЙТ АЛБАН ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СПОРТЫН
4 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Биеийн тамир, спортоор дамжуулан сэтгэл, оюуны болон бие бялдрын боловсрол олгох, идэвхтэй хөдөлгөөн, амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, биеийн тамир, спортын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Зорилго

Цаашид алба хаагчдын амьдралын зөв хэвшил, гоо зүйд анхаарах, хамт олны зэрэг уур амьсгалыг бүрдүүлэх, соёл гэгээрүүлэх, эрүүл чийрэг албан хаагчдыг бэлтгэх хүрээнд Хүүхдийн Урлан Бүтээх төвийн зүгээс жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

Гурав. Тэмцээний төрөл

- Гар бөмбөг – 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр холимог багаар оролцоно. Үндсэн 6 тамирчин сэлгээний 1-2 тамирчин оролцох.
- Ширээний теннис – Эрэгтэй, эмэгтэй гэсэн 2 төрөлд тоглох ба баг бүрээс 1 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчин оролцох.
- Дартс – Хасах онооны журмаар тэмцээн явагдах ба баг бүрээс 2 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчин оролцож түрүүлж 301 оноог дүүргэсэн баг ялагч болно.
- Шатар – Баг тус бүрээс хүйс хамаарахгүй 1 тамирчин оролцох.

/АНХААРАХ ЗҮЙЛ: Ширээний теннис, Дартс, Шатар төрлүүдэд тус бүр өөр өөр тамирчин орох/

Дөрөв. Шагналт

1. Тэргүүн байр – цалингийн 15%-ийн урамшуулал
2. Дэд байр – цалингийн 10%-ийн урамшуулал
3. Гутгаар байр – цалингийн 5%-ийн урамшуулал

Тав. Хугацаа

2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулагдах. (Тодорхой шалтгааны улмаас 7 хоногоор хойшлож болно)

Зургаа. Хаана

Хүүхдийн Урлан Бүтээх төвийн байранд 3 төрлийн тэмцээн, спорт заавланд багийн төрөлд оролцох тэмцээн зохион байгуулагдана.

Долоо. Хамрах хүрээ

Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийт албан хаагчид 6 багт хуувагдан өрсөлдөх.

БОЛОВСРУУЛСАН.
НИЙГМИЙН АЖИЛТАН

 **Б.АРИУНБАТ**

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВ 2025 ОНЫ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХАМТЛАГИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөн, Биеийн тамир, спортын тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Биеийн тамир, спортоор дамжуулан сэтгэл, оюуны болон бие бялдрын боловсрол олгох, идэвхтэй хөдөлгөөн, амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, биеийн тамир, спортын удирдлага, зохион байгуулалт, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бүхий иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир, спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах мэдлэг, мэдээлэл олгох, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, спортод ээлтэй орчин бүрдүүлэх зорилготой биеийн тамирын арга хэмжээг улсын хэмжээн зохион байгуулсантай холбогдуулан Монгол Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн нийт ажилтан, албан хаагчдын дунд 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд 6 багийн 4 төрлийн / гар бөмбөг, шатар, дартс, ширээний теннис / спортын өдөрлөгийг амжилттай зохион байгуулж ажиллав.

Уг спорт өдөрлөгийн хүрээнд:

- 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нийт албан хаагчдыг 6 багт хуваарилан, арга хэмжээний удирдамжийг боловсруулав.
- 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр нийт албан хаагчдын дунд гар бөмбөгийн тэмцээнийг явуулав.
- 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 6 багийн шатар, дартсын тэмцээнийг Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн "Орд арт галлерей"-д зохион байгуулав.
- 2025 оны 10 дугаар сарын 17-ны 6 багийн дунд ширээний теннис тэмцээнийг зохион байгуулав.

Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 2025 оны спорт өдөрлөгийн тэргүүн байр Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Отгонтуяа ахлагчтай "Шанага 7" баг, Дэд байр Захирлын туслах, шуурхай асуудал хариуцсан ажилтан Б.Хосчимэг ахлагчтай "Мөрөөдөл" баг, Гутгаар байр Галерейн эрхлэгч Г.Очгэрэл ахлагчтай "Хөнгөн хэмнэл" баг тус тус шалгарч, арга хэмжээ амжилттай зохион байгуулагдав

Үр дүн:

Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бий болгох, хамт олны эвсэг уур амьсгал бүрдүүлсэн.







(Үйл ажиллагааны зураг)

ХЯНАСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Н.ОТГОНТУЯА

ТАЙЛАГНАСАН:
НИЙГМИЙН АЖИЛТАН  Б.АРИУНБАТ

ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН
БНХАУ-ЫН ХОНГКОНГИЙН ОЛОН УЛСЫН
СУРГУУЛЬТАЙ ХАМТАРСАН
"БҮТЭЭЛЧ ӨДӨРЛӨГ"-ИЙН ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 17

Улаанбаатар хот

Хүүхдийн урлан бүтээх төв дээр БНХАУ-ын Хонгконгийн Олон Улсын ахлах сургуулиас 5 орны (Япон, Солонгос, Энэтхэг, АНУ, Турк) 29 хүүхэд 3 багш хүлээн авч, төвийн 20 сурагч 6 багш оролцсон хамтдаа зураг, гар урлалын бүтээл хийх арга хэмжээг удирдан зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээнд төвийн багш уран бүтээлчид өөрсдийн мастер класс сургалтыг үзүүлж, Монгол зургийн онцлог, зурах арга барил, техникийг хуваалцаж байгууллагын үйл ажиллагаатай танилцав.

Тус төвийн дугуйлангийн сурагчид өөрсдийн хийсэн уран бүтээлийг Олон Улсын сургуулийн зочин сурагчдад бэлэг болгон дурсгав.



Зураг 1: БНХАУ-ын Хонгконгийн Олон Улсын ахлах сургуулийн сурагчид



Зураг 2: Арга хэмжээний үед

ХЯНАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.Отгонтуяа Н.ОТГОНТУЯА

ТАЙЛАГНАСАН:

ГАДААД ХАРИЛЦААНЫ АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.Даваабаяр Д.ДАВААБАЯР

**ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН
БНХАУ-ЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН
"MY STORY WITH CHINA – OPEN DAY" ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам болон Хүүхдийн урлан бүтээх төв хамтран "My Story with China – Open Day" үзэсгэлэнг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 16:00 цагт БНХАУ –ын Элчин Сайдын Яаманд зохион байгуулав. Гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Даваабаяр удирдаж, Галерейн эрхлэгч Г.Очгэрэл, Арьсан урлалын дугуйлангийн багш Э.Бямбасүрэн нар үзэсгэлэнг дэглэн удирдаж ажилласан.

Тус үзэсгэлэнд төвийн багш, албан хаагчид 13 дугуйлангийн сурагч 27 оролцов. Арга хэмжээнд Монгол уран бичлэг, уран зураг, гар урлалын дугуйлангийн багш нар өөрсдийн хийсэн уран бүтээлийг бэлдэц дээр тулгуурлан бүтээл гаргаж оролцогч хүүхдүүдэд бэлэглэв.

Уг арга хэмжээний зардалд шаардагдах 292.000 төгрөгийг БНХАУ –ын ЭСЯ –аас гаргаж уран бичлэгийн бэлдэц, гар зургийн цаас зэрэг материалуудыг авсан.



Зураг 1: Нээлттэй өдөрлөгийн үеэр



Зураг 2: Бэлтгэл ажил



Зураг 3: Үүдний хэсэгт байрласан хүүхдийн уран бүтээлүүд.



Зураг 4: Үндсэн үйл ажиллагааны заалны хэсгийн үзэсгэлэн



Зураг 5: Ажлын хэсгийн хамт олон



Зураг 6: Хоёр дугаар ажлын хэсэг

ХЯНАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

H. Otgontuya

Н.ОТГОНТУЯА

ТАЙЛАГНАСАН:

ГАДААД ХАРИЛЦААНЫ АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

D. Davabayar

Д.ДАВААБАЯР



МӨНХ ТЭНГЭРИЙН БИЧИГ - 2025

МОНГОЛ УРАН БИЧЛЭГИЙН
ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН

“МӨНХ ТЭНГЭРИЙН БИЧИГ – 2025” МОНГОЛ УРАН БИЧЛЭГИЙН ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНГИЙН УДИРДАМЖ

Зорилго:

Их эзэн Чингис хааны мэндэлсэн Монгол бахархлын өдөрт зориулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар уламжлал болгон зохион байгуулдаг “Мөнх тэнгэрийн бичиг” монгол уран бичлэгийн олон улсын үзэсгэлэн нь монгол бичиг соёлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, уран бүтээлчид, багш, оюутан, сурагчдын шинэлэг санаа, санаачилга, авьяас чадварыг нийтэд таниулах, дэмжихэд оршино.

Ерөнхий зохион байгуулагч:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар

Хамтран зохион байгуулагч:

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
- Боловсролын яам
- Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл
- Боловсролын ерөнхий газар
- Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг
- Монголын Хүүхдийн урлан бүтээх төв
- Монголын Урчуудын эвлэл
- Монгол Улсын Их Сургууль
- ШУА-ын Хэл, зохиолын хүрээлэн
- Олон улсын Монгол уран бичлэгийн холбоо
- Бичиг соёл төв

ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хамрах хүрээ: Уран бүтээлчид, Ерөнхий боловсролын сургуулийн багш, оюутнууд, 8-12 дугаар ангийн сурагчид

Ангилал:

Уран бүтээлчид

- Уран бичлэг, хэмжээ хязгаарлахгүй, жаазалсан байх

Ерөнхий боловсролын сургуулийн багш нар

- Уран бичлэг, хэмжээ хязгаарлахгүй, жаазалсан байх

Оюутнууд

- Уран бичлэг, хэмжээ хязгаарлахгүй, жаазалсан байх

Сурагчид

- 11-12 дугаар анги: Уран бичлэг, хэмжээ хязгаарлахгүй, жаазалсан байх
- 8-10 дугаар анги: Бийрийн болон үзгийн хичээнгүй тиг, жаазалсан байх

Санамж:

1. Бүтээлийн ард овог, нэр, утасны дугаар, эрхэлж буй ажил, албан тушаал болон бүтээлийн нэр, төрөл, хэмжээ, оролцох ангиллыг тодорхой бичих
2. Товч танилцуулга, зургаа цахим хаягаар илгээхдээ гарчиг хэсэгт овог, нэрээ бүтээлийн нэрийн хамт тодорхой бичих

Бүтээлийг хүлээж авах газар: Монголын Хүүхдийн урлан бүтээх төв

Цахим хаяг: khukhdiinurlani@gmail.com

Холбогдох утасны дугаар: 99978546, 88555616, 99880509

Бүтээл хүлээн авах хугацаа: 2025 оны 11 дүгээр 14-ний өдөр хүртэл ажлын өдрүүдэд 09:00-17:00 цаг

“МӨНХ ТЭНГЭРИЙН БИЧИГ 2025” МОНГОЛ УРАН БИЧЛЭГИЙН ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

Их эзэн Чингис хааны мэндэлсэн Монгол бахархлын өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулагддаг “МӨНХ ТЭНГЭРИЙН БИЧИГ-2025” Монгол уран бичлэгийн олон улсын үзэсгэлэн 14 дэх жилдээ уламжлал болгон зохион байгуулагдсан. Энэхүү үзэсгэлэн нь үндэснийхээ бичиг соёлын өв уламжлалыг хайрлан хамгаалах, өвлүүлэн сурталчлах, хүүхэд залуучуудад сурах, судлах тэмүүллийг бий болгох, монгол бичгийн соёлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, уран бүтээлчид, багш, оюутан, сурагчдын авьяас чадварыг дэмжихэд оршино.

Үзэсгэлэнд монгол улсын уран бүтээлчдээс гадна ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, Бүгд Найрамдах Халимаг Улс, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орон, Хөх Нуурын Дээд монгол болон Бүгд Найрамдах Франц улсын Мэргэжлийн уран бүтээлч, Багш, Оюутан, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын нийт 260 гаруй бүтээл дэлгэгдсэн.

Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн "Орд" арт галерейд Их эзэн Чингис хааны мэндэлсэн Монгол бахархлын өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулагддаг “МӨНХ ТЭНГЭРИЙН БИЧИГ-2025” Монгол уран бичлэгийн олон улсын үзэсгэлэн нь дэлгэгдсэн бөгөөд Ерөнхий зохион байгуулагчаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, хамтран зохион байгуулагчаар Монголын Хүүхдийн урлан бүтээх төв, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Боловсролын яам, Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Боловсролын ерөнхий газар, Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг, Монголын Урчуудын эвлэл, Монгол Улсын Их Сургууль, ШУА-ын Хэл, зохиолын хүрээлэн, Олон улсын Монгол уран бичлэгийн холбоо, Бичиг соёл төв оролцлоо.

Мөн тус үзэсгэлэнд энэ жил Монголын Фелателийн холбооны хүндэт гишүүн Дэндэвийн Дашжавын “Чингис хаан ба түүний залгамжлагчид” сэдэвт шуудангийн маркнууд тавигдсан нь онцлог болсон.









ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ДОТООД ХЯНАЛТ, ХУУЛИЙН
ЗӨВЛӨХ

B. Bayanmunkh

Б.БАЯНМӨНХ